



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/003/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням Утас:51-261885 Цахим хаяг: sambuunyamyaya@audit.gov.mn Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Нямцэцэг Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegi@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас: 51-261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn Аудитор: Г.Тэлмүүн Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.05.05 № 1705
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.7-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн хэрэгжүүлэгч этгээдийг тогтоох тухай” 25 дугаар тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Сангийн сайдын багцын гааль, татварын орлогоос 20,676,487.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 21,071,532.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 395,045.0 сая төгрөгөөр давсан байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д Үндэсний баялгийн сангийн төсөв нь Монгол Улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн байхаар заасан боловч 2024 оны төсвийн тухай хуулиар Баялгийн сангийн төрөлжсөн сангуудын орлогыг Сангийн сайдын төсөвт баталсанаас шалтгаалж Хуримтлалын сан, Ирээдүй өв сангийн тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байна. Мөн Ирээдүй өв сангийн 3,974,518.6 сая төгрөг, Хуримтлалын сангийн 500,000.0 сая төгрөг, нийт 4,474,518.6 сая төгрөгийг Монгол банканд тусгаарласан байна.

Бусад асуудлын хэсэг

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч "S&P" агентлагаас Монгол улсын 2024 оны зээлжих зэрэглэлийг "B+ зэрэг" болж сайжирсныг мэдэгдсэн байна. Зээлжих зэрэглэл тогтоогч "Fitch Ratings", "S&P", "Moody's" гэсэн олон улсын агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "B+зэрэг" "B+тогтвортой" болгон нэмэгдүүлснээр Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулагчдын итгэх итгэл сайжирч, шууд хөрөнгө оруулалтын суурь бэхжиж, улмаар зээлжих зэрэглэл дахин өсөх боломж бүрдсэн байна.

"Монгол-Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2021 оны 94 дүгээр тогтоол, Засгийн газрын 2021 оны 380 дугаар тогтоолуудын дагуу дүрмийн сангийн хэмжээг 83,673.5 сая төгрөгөөр тогтоож, Монгол талын эх үүсвэрийг Японы Олон улсын хамтын ажиллагааны банкнаас тус нийгэмлэгт төмөр замын тээврийг сэргээн сайжруулахад зориулан олгосон "МОН-П1", "МОН-П2" хөнгөлөлттэй зээлийн үндсэн төлбөрийн авлагаас шилжүүлэн тооцох замаар бүрдүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-д заасны дагуу төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гарган өгч, мэдээллээр бүрэн хангаж ажилласан.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАГДЖАВ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,593,899,287.0	16,612,629,486.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,749,372,966.4	7,966,202,948.4
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	418,236,563.0	1,839,798,831.9
33	АВЛАГА	570,214,671.7	169,179,817.5
34	УРЬДЧИЛГАА	478,425,619.9	534,545,023.9
35	БАРАА МАТЕРИАЛ	21,239,399.9	57,156,954.8
36	НӨӨЦИЙН БАРАА	-	2,839.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	4,356,410,066.1	6,045,743,070.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,831,386,206.9	4,627,994,609.2
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4,887,689,342.4	3,825,104,947.2
37100	Урт хугацаат хадгаламж	60,011,802.6	57,967,999.0
37200	Үнэт цаас	1,372,805,698.6	431,263,979.9
37300	Урт хугацаат зээл	3,454,871,841.2	3,335,872,968.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	943,696,864.5	802,889,662.0
39200	Биет хөрөнгө	600,045,938.3	720,331,580.5
39300	Биет бус хөрөнгө	42,667,994.9	49,393,191.8
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	300,982,931.3	33,164,889.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	19,425,285,493.9	21,240,624,095.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,938,831,295.6	6,942,645,836.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,065,255,378.9	4,158,512,582.7
41100	Богино хугацаат үнэт цаас	497,224,863.0	10,044,464.2
41200	Богино хугацаат зээлийн өглөг	2,356,585,467.4	3,001,059,900.9
41300	Өглөг	1,179,601,317.5	1,105,815,391.0
41400	Урьдчилж орсон орлого	31,843,731.1	41,592,826.6
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,873,575,916.6	2,784,133,253.6
42100	Урт хугацаат үнэт цаас	777,405,460.2	106,875,646.8
42200	Урт хугацаат зээл	3,096,170,456.5	2,677,257,606.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,486,454,198.4	14,297,978,259.6
51	Засгийн газрын хувь оролцоо	11,475,680,135.9	14,287,204,197.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	98,768,141.4	98,664,653.4
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,401,300,340.6	185,000,000.0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	59,546,353.9	59,546,353.9
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	14,652,725.0	14,652,725.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	125,382,903.2	132,941,861.8
51200	Хуримтлагдсан үр дүн	9,641,259,903.0	13,700,531,074.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	134,769,768.7	95,866,161.1
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	1,366.9
52	Хяналтын бус хувь оролцоо	10,774,062.5	10,774,062.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	19,425,285,493.9	21,240,624,095.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,972,342,013.4	7,933,473,523.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	675,923,081.4	1,283,647,938.2
110	Орлогын албан татвар	92,182,854.0	144,350,403.5
1103	ААН-ын орлогын албан татвар	92,182,854.0	144,350,403.5
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	-	1,280,625.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	583,740,227.4	1,138,016,909.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,068,283,835.4	4,126,776,596.0
120	Нийтлэг татварын бус орлого	2,750,697,351.4	3,684,392,384.5
122	Тусламжийн орлого	310,793,288.2	423,534,015.2
124	Зээлийн орлого	6,793,195.8	18,850,196.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,228,135,096.5	2,523,048,989.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,062,778,123.1	3,662,797,901.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,060,565,757.2	3,659,529,484.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	703,425,878.0	1,140,837,827.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226,895,802.2	310,266,631.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,165,739.1	38,051,598.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,856,118.8	16,632,505.7
2104	Хангамж, бараа материалын зардал	13,963,785.7	18,682,050.7
2105	Нормативт зардал	2,050,672.8	2,407,018.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,295,625.0	8,759,914.3
2107	Томилолт, зочны зардал	6,394,321.0	9,006,268.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,509,665.3	393,564,214.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	205,294,148.1	343,467,625.7
211	ХҮҮ	1,569,628,160.4	1,545,335,661.1
212	ТАТААС	56,151,666.2	26,066,423.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	731,360,052.6	947,289,572.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,212,365.9	3,268,417.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,909,563,890.3	4,270,675,622.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	16,610,433.7	32,823,090.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	537,428,190.5	683,972,622.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,388,746,133.5	3,619,526,090.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,132,078,651.8	-	9,132,078,651.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(28,761,527.9)	-	(28,761,527.9)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,103,317,123.9	-	9,103,317,123.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	19,772,032.9	-	19,772,032.9
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(14,112,292.6)	-	(14,112,292.6)
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	12,667,504.7	-	12,667,504.7
7	Өмчид гарсан өөрчилөлт	10,102,237.6	-	10,102,237.6
8	Зарласан ногдол ашиг	(49,039,594.3)	-	(49,039,594.3)
9	Тайлант үеийн үр дүн	2,403,747,186.1	-	2,403,747,186.1
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,486,454,198.4	-	11,486,454,198.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	507,758,600.8	-	507,758,600.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,994,212,799.1	-	11,994,212,799.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	41,414.2	-	41,414.2
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(3,124,468.4)	-	(3,124,468.4)
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	737,726.0	-	737,726.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	(1,251,514,396.7)	-	(1,251,514,396.7)
18	Зарласан ногдол ашиг	(61,900,904.7)	-	(61,900,904.7)
19	Тайлант үеийн үр дүн	3,619,526,090.0	-	3,619,526,090.0
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,297,978,259.6	-	14,297,978,259.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	12,542,571,322.8	27,392,113,651.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	743,651,675.2	1,283,070,954.3
110	Орлогын албан татвар	92,182,854.0	144,350,403.5
1103	ААН-ын орлогын албан татвар	92,182,854.0	144,350,403.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	651,468,821.2	1,138,720,550.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	651,468,821.2	1,138,720,550.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,244,244,671.3	23,040,583,288.7
120	Нийтлэг татварын бус орлого	9,209,136,694.3	22,992,163,520.6
122	Тусламжийн орлого	35,107,977.1	48,419,768.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,554,674,976.2	3,068,459,408.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,339,155,284.2	26,459,379,627.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,339,155,284.2	26,459,379,627.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,534,368,748.8	23,473,197,194.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,714,922.6	309,216,032.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,562,560.7	39,823,923.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,730,084.7	15,281,552.5
2104	Хангамж, бараа материалын зардал	12,524,034.6	24,423,919.3
2105	Нормативт зардал	2,094,201.0	2,612,678.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,625,546.5	14,750,099.9
2107	Томилолт, зочны зардал	5,125,587.4	6,522,587.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,130,158,184.5	22,916,758,774.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,833,626.8	143,807,626.5
211	ХҮҮ	1,618,119,739.6	1,538,121,905.7
212	ТАТААС	56,151,666.2	26,066,423.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,130,515,129.5	1,421,994,104.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,203,416,038.6	932,734,023.5
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	10,818,953,983.7	17,689,409,800.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	11,185,932,431.0	18,099,843,876.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,185,932,431.0	18,099,843,876.6
2200	Дотоод эх үүсвэрээр	11,185,932,431.0	18,099,843,876.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(366,978,447.3)	(410,434,076.4)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(1,826,019,344.8)	(305,469,965.0)
14	Бусад эх үүсвэр	1,483,536,961.2	1,037,455,087.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	79,262,815.9	458,189,288.4
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3,230,293,490.1	884,735,763.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,010,418,246.5	216,829,982.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,738,954,719.9	7,749,372,966.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,749,372,966.4	7,966,202,948.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,234,762,307,600.00	5,038,893,559,727.73	195,868,747,872.27	96.3
УРСГАЛ ЗАРДАЛ	2,782,069,138,600.00	2,681,673,378,658.36	100,395,759,941.64	96.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	651,361,906,100.00	621,650,958,310.49	29,710,947,789.51	95.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,370,617,200.00	168,160,693,170.17	9,209,924,029.83	94.8
Үндсэн цалин	90,737,044,300.00	86,076,626,415.88	4,660,417,884.12	94.9
Нэмэгдэл	41,984,549,700.00	40,265,505,579.21	1,719,044,120.79	95.9
Унаа хоолны хөнгөлөлт	15,658,131,200.00	15,002,648,016.10	655,483,183.90	95.8
Урамшуулал	28,990,892,000.00	26,815,913,158.98	2,174,978,841.02	92.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,432,558,300.00	21,218,745,806.98	1,213,812,493.02	94.6
Тэтгэврийн даатгал	15,130,979,900.00	14,353,345,537.60	777,634,362.40	94.9
Тэтгэмжийн даатгал	2,223,230,300.00	2,042,770,160.57	180,460,139.43	91.9
ҮОМШӨ-ний даатгал	1,043,456,600.00	979,845,340.70	63,611,259.30	93.9
Ажилгүйдлийн даатгал	841,768,900.00	751,859,990.29	89,908,909.71	89.3
Эрүүл мэндийн даатгал	3,193,122,600.00	3,090,924,777.82	102,197,822.18	96.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,060,769,000.00	10,463,563,170.19	1,597,205,829.81	86.8
Гэрэл, цахилгаан	3,352,941,500.00	2,614,041,474.75	738,900,025.25	78.0
Түлш, халаалт	4,161,231,300.00	3,574,386,732.94	586,844,567.06	85.9
Цэвэр, бохир ус	707,983,800.00	569,345,650.80	138,638,149.20	80.4
Байрны түрээс	3,838,612,400.00	3,705,789,311.70	132,823,088.30	96.5
Хангамж, бараа материалын зардал	11,310,606,700.00	11,028,231,184.21	282,375,515.79	97.5
Бичиг хэрэг	748,629,000.00	706,279,263.54	42,349,736.46	94.3
Тээвэр, шатахуун	9,012,916,000.00	8,920,254,957.36	92,661,042.64	99.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	631,334,800.00	541,865,300.32	89,469,499.68	85.8
Ном, хэвлэл	6,524,500.00	2,119,196.00	4,405,304.00	32.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	58,571,400.00	53,960,968.00	4,610,432.00	92.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	852,631,000.00	803,751,498.99	48,879,501.01	94.3
Нормативт зардал	2,860,024,500.00	2,612,678,734.82	247,345,765.18	91.4
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	747,605,200.00	725,123,056.00	22,482,144.00	97.0
Хоол, хүнс	173,170,800.00	160,828,978.82	12,341,821.18	92.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,939,248,500.00	1,726,726,700.00	212,521,800.00	89.0
Эд хогшил, урсгал засварын зардал	14,021,409,900.00	13,050,103,010.58	971,306,889.42	93.1
Багаж, техник, хэрэгсэл	7,650,437,600.00	7,174,421,420.67	476,016,179.33	93.8
Тавилга	326,199,400.00	288,229,250.00	37,970,150.00	88.4
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	187,304,300.00	136,100,164.00	51,204,136.00	72.7
Урсгал засвар	5,857,468,600.00	5,451,352,175.91	406,116,424.09	93.1
Томилолт, зочны зардал	4,665,283,400.00	3,536,244,224.81	1,129,039,175.19	75.8
Гадаад албан томилолт	1,467,002,800.00	912,280,275.90	554,722,524.10	62.2
Дотоод албан томилолт	3,148,122,100.00	2,611,029,237.91	537,092,862.09	82.9
Зочин төлөөлөгч хүлээн авах	50,158,500.00	12,934,711.00	37,223,789.00	25.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	269,077,227,400.00	256,572,298,274.33	12,504,929,125.67	95.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	247,100,498,800.00	237,107,906,058.60	9,992,592,741.40	96.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	474,597,000.00	360,008,872.73	114,588,127.27	75.9
Даатгалын үйлчилгээ	270,985,100.00	190,683,037.43	80,302,062.57	70.4
Тээврийн хэрэгслийн татвар	28,305,900.00	18,419,483.75	9,886,416.25	65.1
Тээврийн хэрэгслийн оношлогоо	6,533,300.00	3,802,500.00	2,730,800.00	58.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,305,672,500.00	9,780,727,061.42	524,945,438.58	94.9
Газрын төлбөр	65,626,400.00	56,968,294.00	8,658,106.00	86.8

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,436,845,000.00	2,694,646,866.40	1,742,198,133.60	60.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,388,163,400.00	6,359,136,100.00	29,027,300.00	99.5
Бараа үйлчилгээний бусад зардал	137,563,409,700.00	135,008,400,734.40	2,555,008,965.60	98.1
Бараа үйлчилгээний бусад зардал	136,821,492,300.00	134,432,150,583.00	2,389,341,717.00	98.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	741,917,400.00	576,250,151.40	165,667,248.60	77.7
ХҮҮ	1,173,620,160,000.00	1,165,918,905,156.26	7,701,254,843.74	99.3
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	1,166,119,714,800.00	1,158,449,813,375.44	7,669,901,424.56	99.3
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	1,166,119,714,800.00	1,158,449,813,375.44	7,669,901,424.56	99.3
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	7,500,445,200.00	7,469,091,780.82	31,353,419.18	99.6
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	7,500,445,200.00	7,469,091,780.82	31,353,419.18	99.6
ТАТААС	53,646,444,600.00	26,066,423,651.91	27,580,020,948.09	48.6
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	12,969,457,200.00	12,969,457,200.00	-	100.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	12,969,457,200.00	12,969,457,200.00	-	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	40,676,987,400.00	13,096,966,451.91	27,580,020,948.09	32.2
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	40,676,987,400.00	13,096,966,451.91	27,580,020,948.09	32.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	903,440,627,900.00	868,037,091,539.70	35,403,536,360.30	96.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	879,735,691,200.00	852,632,860,121.57	27,102,831,078.43	96.9
Засгийн газрын дотоод шилжүүлэг	878,645,319,000.00	851,955,071,200.00	26,690,247,800.00	97.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,090,372,200.00	677,788,921.57	412,583,278.43	62.2
Бусад урсгал шилжүүлэг	23,704,936,700.00	15,404,231,418.13	8,300,705,281.87	65.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,185,760,000.00	1,142,723,000.00	43,037,000.00	96.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	294,832,000.00	290,550,000.00	4,282,000.00	98.5
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,799,501,800.00	2,886,485,749.64	1,913,016,050.36	60.1
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,676,122,600.00	10,509,614,228.49	6,166,508,371.51	63.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	748,720,300.00	574,858,440.00	173,861,860.00	76.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,352,226,204,000.00	2,084,550,047,741.41	267,676,156,258.59	88.6
Барилга байгууламж	2,037,110,912,500.00	1,808,041,006,264.22	229,069,906,235.78	88.8
Их засвар	2,618,000,000.00	1,578,538,279.05	1,039,461,720.95	60.3
Тоног төхөөрөмж	260,599,581,300.00	234,202,460,065.60	26,397,121,234.40	89.9
Бусад хөрөнгө	51,897,710,200.00	40,728,043,132.54	11,169,667,067.46	78.5
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,466,965,000.00	272,670,133,327.96	(172,203,168,327.96)	271.4
Эргэж төлөгдөх зээл	(359,533,035,000.00)	(185,939,538,094.73)	(173,593,496,905.27)	51.7
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	460,000,000,000.00	458,609,671,422.69	1,390,328,577.31	99.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,234,762,307,600.00	5,016,719,142,939.98	218,043,164,660.02	95.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,945,855,874,800.00	2,836,623,859,781.12	109,232,015,018.88	96.3
Улсын төсвөөс санхүүжих	2,945,855,874,800.00	2,836,623,859,781.12	109,232,015,018.88	96.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,218,217,649,200.00	2,057,063,571,177.43	161,154,078,022.57	92.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,971,942,000.00	5,051,356,444.36	(79,414,444.36)	101.6

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,245,707,200.00	4,435,583,010.04	(189,875,810.04)	104.5
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,209,000,000,000.00	2,047,576,631,723.03	161,423,368,276.97	92.7
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	558,000,000,000.00	436,749,425,574.16	121,250,574,425.84	78.3
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	558,000,000,000.00	436,749,425,574.16	121,250,574,425.84	78.3
БУСАД ЭХ ҮҮСВЭР	(487,311,216,400.00)	(313,717,713,592.73)	(173,593,502,807.27)	64.4
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(487,311,216,400.00)	(313,717,713,592.73)	(173,593,502,807.27)	64.4
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	9,097	8,179	918	89.9
БАЙГУУЛЛАГЫН ТОО	37	37	-	100.0
Төсвийн байгууллага	37	37	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	4,530	4,071	459	89.9
Удирдах ажилтан	123	123	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	3,741	3,320	421	88.7
Үйлчлэх ажилтан	666	628	38	94.3
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	4,530	4,071	459	89.9
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,843	1,823	20	98.9
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	1,932	1,534	398	79.4
Ажлын албаны албан хаагч (АА)	3	3	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	687	646	41	94.0
Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	-	100.0
УТҮГ	63	63	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		18,012,588,474.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ		17,982,588,474.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		15,042,140,505.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,378,419,470.09
210101	Үндсэн цалин		174,134,552.69
210102	Нэмэгдэл		1,660,155,433.91
210104	Урамшуулал		456,717,904.38
210105	Гэрээт ажлын хөлс		87,411,579.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		299,505,561.49
210201	Тэтгэврийн даатгал		237,600,993.31
210202	Тэтгэмжийн даатгал		15,369,624.38
210203	ҮОМШӨ-ний даатгал		7,903,430.87
210204	Ажилгүйдлийн даатгал		7,107,307.64
210205	Эрүүл мэндийн даатгал		31,524,205.29
2104	Хангамж, бараа материалын зардал		679,674,555.31
210401	Бичиг хэрэг		333,401,220.00
210402	Тээвэр, шатахуун		191,761,635.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		48,428,280.31
210404	Ном, хэвлэл		23,971,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		82,111,920.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,254,588,222.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		709,665,900.00
210602	Тавилга		83,570,690.00
210604	Урсгал засвар		461,351,632.00
2107	Томилолт, зочны зардал		97,280,607.00
210701	Гадаад албан томилолт		78,469,607.00
210702	Дотоод албан томилолт		18,811,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,729,279,458.80

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,034,807,078.00
210803	Даатгалын үйлчилгээ		195,940.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		48,400,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		645,854,440.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		8,603,392,631.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		7,897,747,475.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		705,645,156.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,940,447,968.76
2132	Бусад урсгал шилжүүлэг		663,957,977.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		79,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		584,457,977.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		2,276,489,991.76
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		29,694,370.33
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг		2,246,795,621.43
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		30,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		30,000,000.00
223001	Бусад хөрөнгө		30,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		18,012,588,474.53
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		18,012,588,474.53
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		585,446,852.00
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,026,970,933.46
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,560,399,473.63
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,839,771,215.44
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагч 2, Засгийн газрын 4 тусгай сан, төрийн өмчит аж ахуйн нэгж 7, төсвийн шууд захирагч 56, төсөл хөтөлбөрийн 137 нэгж, нийт 206 байгууллагын санхүүгийн тайлан, 19 данс нэгтгэгдсэнээс 93 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж “Өөрчлөлтгүй” 80, “Хязгаарлалттай” 13, санал дүгнэлт өгч, 132 байгууллага, 19 данс түүвэрт хамрагдсан. “Горхи, мэлхий хад” амралтын газар үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаар аудитад хамрагдаагүй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаар илэрсэн нийт 55,605.2 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 9,596.4 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн.

3.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн, алдаа зөрчил

Аудитаар нийт 609,215.9 сая төгрөгийн 187 алдаа¹ илэрснээс аудитын явцад 608,747.1 сая төгрөгийн 183 алдааг залруулж, 48.1 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 55,557.1 сая төгрөгийн 191 зөрчил² илэрснээс, 372.1 сая төгрөгийн 28 төлбөрийн акт тогтоож, 43,060.2 сая төгрөгийн зөрчилд 86 албан шаардлага хүргүүлж, 12,072.7 сая төгрөгийн зөрчилд 74 зөвлөмж, 2.3 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага, 49.8 сая төгрөгийн 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

3.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Дотоод аудитын хяналт хангалтгүйгээс Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар санхүүгийн тайлантай холбоотой нийт 55,605.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос 25,779.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тухайлбал:

1. Төсөл хөтөлбөрийн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс нийт 593,714.7 сая төгрөгийн 83 алдаа, 48,535.0 сая төгрөгийн 68 зөрчил, нийцлийн асуудалтай холбоотой 158,017.7 сая төгрөгийн 45 зөрчил;
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж болон засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайлан аудитаар нийт 15,080.4 сая төгрөгийн 104 алдаа, 7,070.2 сая төгрөгийн 124 зөрчил, нийцлийн асуудалтай холбоотой 3,884.4 сая төгрөгийн 59 зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна", 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын санхүүгийн нийт зөрчлийн дүн өмнөх оноос нэмэгдсэн асуудалд тодорхой арга хэмжээ авч, алдаа, зөрчлийг 30.0 хувиар бууруулж ажиллах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

3.2.2 Зөвлөмж

Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж байгаа гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл хөтөлбөрийн нэгжийн тайлант оны гүйцэтгэлтэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тайлант онд зээлийн ашиглалт гараагүй 47 ТХН;
- Тайлант онд төсөв баталсан боловч гүйцэтгэл гараагүй 11 ТХН;
- Тайлант онд хэрэгжиж дуусахаар батлагдсан боловч хугацаа сунгасан 11 ТХН;
- Үндсэн гүйцэтгэгч нь дампуурсан шүүхийн шатанд байгаа 1, санхүүжилт гацсан 1 ТХН.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дугаар зүйлийн 69.1-д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна", 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна", Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх", 7 дугаар зүйлийн 7.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид шилжүүлэх, төслийн хэрэгжилт, гүйцэтгэл, хугацаа, тайлагналд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт хэрэгжүүлэх замаар үүрэг хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх.

3.3 Түүврийн байгууллага

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудитаар түүвэрт хамрагдсан 4 байгууллагын санхүүгийн тайланд 41,146.6 сая төгрөгийн алдааг залруулсан.

- Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төслийн ТЭЗҮ боловсруулах, дулаан хангамжийн системд сэргээгдэх эрчим хүчийг нэгтгэх судалгаа, захиалагчийн хяналт хийх зөвлөх үйлчилгээний 3,260.1 сая төгрөгийн зардлыг бүртгэж, тайлагнаагүй;
- Архивын ерөнхий газрын цогцолбор тоног төхөөрмжийн техник хэрэгслийн хангалт төсөл нь төслийн хүрээнд бэлтгэсэн 37,034.9 сая төгрөгийн Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг санхүүгийн тайланд бүртгээгүй;
- Нүхэн гарц төсөл нь НЗДТГ-т хэрэгжиж байгаа Нүхэн гарц төслийн Монгол талын хариуцах зардлын тайлант оны санхүүжилтийн 849.5 сая төгрөгийг төслийн хэрэгжүүлэгч нэгжийн эргэлтийн хөрөнгөд бүртгэж тайлагнаагүй;
- Аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл нь дараа онд төлөх даатгалын 2.0 сая төгрөгийг урьдчилан төлж, шууд зардлаар тайлагнасан.

Залруулсан алдаа: УСНББОУС-1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр

төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг”, санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй дээрх алдааг аудитын явцад бүрэн залрууллаа.

3.3.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Мазаалай баавгайн амьдрах орчны нөхцлийг сайжруулах төсөл нь төслийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 179.0 сая төгрөгийн балансын үнэтэй, 89.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй Land cruiser 200 маркын 1 тээврийн хэрэгсэл нь төслийн үйл ажиллагаанд ашиглагдахгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-т "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төслийн дансанд бүртгэлтэй хөрөнгийг зориулалтын дагуу үйл ажиллагаандаа ашиглаагүй, бусдад ашиглуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Ногоон нуур 1008 айл орон сууц төсөл нь төсөл хэрэгжүүлэгч нэгжийн орон тооны жагсаалтад орчуулагчийн орон тоо батлагдсан боловч бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас орчуулагчийн зардалд 28.7 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "... төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

